



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Хамтарсан баг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаалыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит есдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Чингэлтэй дүүргийн 1-24 дүгээр хороодод гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгааллын үйлчилгээг хамтран үзүүлэх чиг үүрэг бүхий хамтарсан багийг хавсралт ёсоор байгуулсугай.

2.Хамтарсан багийг арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Б.МӨНХБАТ

1159197028

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 19-ны
өдрийн 06 дугаар тогтоолын хавсралт

Чингэлтэй дүүргийн хороодын
хамтарсан багийн бүрэлдэхүүн

Хамтарсан багийн ахлагч: Хорооны Засаг дарга

Гишүүд: Хорооны хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
мэргэжилтэн

Ерөнхий боловсролын сургуулийн Нийгмийн
ажилтан

Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч

Хэсгийн байцаагч

Нарийн бичгийн дарга: Хорооны нийгмийн ажилтан

Зөвшилцсөнөөр: Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын
Арга зүйч

Хүүхэд, гэр бүлд үйлчилгээ үзүүлдэг төрийн
бус байгууллагын төлөөлөл